



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/415

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км замын засварын ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Балжинням - Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын авто замын улсын байцаагч

Б.Ариундолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

А.Энхбаяр - Дуут сумын Засаг дарга

Х.Соронзонболд-Дуут сумын Шивэр багийн Засаг дарга

Л.Алтанцэцэг - Дуут сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

З.Виктор - Дуут сумын иргэдийн төлөөлөл


Нарийн бичгийн дарга: Ц.Сувдаа - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

02 01818
D/Zah-A/415-Bo

2. Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км замын засварын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН